



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио,
телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх,
хяналт тавих журам батлах тухай**


Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.20 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт"-ын маягтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг/, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /Б.Бат-Эрдэнэ/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/, Цагдаагийн ерөнхий газар /Ж.Болд/, Тагнуулын ерөнхий газар /П.Одонбаатар/-т тус тус даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000064

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 2 дугаар сарын 1-ны өдрийн
32 дугаар тогтоолын 7.1.1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИАР РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг радио, телевизээр нэвтрүүлэх, хяналт тавих, түүнтэй холбоотой өргөдөл, гомдол шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасан радио, телевизэд Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид хамаарна.

1.3. Радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, дамжуулахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавихдаа хууль дээдлэх, ил тод, түргэн шуурхай, тэнцвэрт байдлыг хангах зарчмыг баримтална.

Хоёр. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх радио, телевизийг бүртгэх

2.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэхүү журмын 3.12-т зааснаас бусад радио, телевизийн үндсэн сувгийн жагсаалтыг эзэмшлийн мэдээллийн хамт сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө батлагдсан маягтын дагуу гаргаж, өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасны дагуу жагсаалтад орсон радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9-д заасны дагуу сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлэх эрхтэй байна.

2.3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийн маягт гаргаж, цахим хуудсаар мэдээлнэ.

2.4. Энэ журмын 2.3-т заасан мэдэгдлийн маягтад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9-д заасан мэдээлэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, энэхүү журмыг мөрдөж ажиллах тухай мэдэгдэл гаргагчийн баталгаа, сонгуулийн үеэр харилцах эрх бүхий албан тушаалтны холбоо барих мэдээллийг багтаасан байна.

2.5. Энэ журмын 2.2-т заасан радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх бол сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийн маягтыг бөглөж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.1-41.9.3-т

заасан баримтыг бүрдүүлэн хуульд заасан хугацаа дуусахаас өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэхээр ирүүлнэ.

2.6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.1-д заасан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх төлөвлөсөн цагийн хуваарийг гаргаж ирүүлэхдээ сонгуулийн сурталчилгаа дамжуулах нийт хугацааны туршид сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг, зар сурталчилгааны цагийг хөтөлбөрийн сүлжээнд хуваарилна.

2.7.Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээс ирүүлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдлийг бүртгэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9-д заасан баримт бичгийг хянаж, шалгана.

2.8.Харилцаа холбооны зохицуулах хороо нь дараах шаардлага хангасан радио, телевизийг бүртгэнэ:

2.8.1.энэ журмын 2.1-т заасан жагсаалтад орсон;

2.8.2.мэдэгдэлд хавсаргасан баримт бичгийг хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэд ирүүлсэн;

2.8.3.сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх дундаж үнийн санал нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д нийцсэн;

2.8.4.сонгуулийн сурталчилгаа явуулахаар төлөвлөсөн цагийн хуваарь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6, 41.7-д нийцсэн.

2.9.Энэ журмын 2.8-д заасан шаардлага хангаагүй радио, телевизийг бүртгэхээс татгалзана.

2.10.Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээс ирүүлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд үндэслэлийг мэдэгдэлд дурдсан цахим хаягаар 48 цагийн дотор шуурхай мэдэгдэх бөгөөд радио, телевиз нь хуульд заасан хугацаанд дахин мэдэгдэл гаргах эрхтэй.

2.11.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 2.8-д заасны дагуу хянаж, бүртгэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн жагсаалтыг баталж, цахим хуудсандаа байршуулан нийтэд ил тод мэдээлнэ.

2.12.Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг гаргахдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3, 41.11, 41.12, 41.18-д нийцүүлэн дараах зарчмыг баримтална.

2.12.1.сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн үндсэн сувгаар, төлбөргүй нэвтрүүлэх;

2.12.2.сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нэг нам, эвслээс нэр дэвшигчид ногдох хугацаа нь 15 минутаас илүүгүй байх;

2.12.3.оргил цаг болон сонгуулийн сурталчилгааны сүүлийн өдрүүдийн цагийг нам, эвслийн нэр дэвшигчдэд ижил боломж, нөхцөлөөр хуваарилах;

2.12.4.сурталчилгааны дарааллыг тооцохдоо сонгуулийн сурталчилгааны сүүлчийн өдрийн сүүлийн хуваарьт цагаас эхлэн тоолох зарчмаар хуваарилах.

2.13. Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийг гаргахад баримталсан зарчим, дүрмээ нам, эвсэл, нэр дэвшигчид болон олон нийтэд ил тод мэдээлэх;

2.14. Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх санал, хуваарь, цаг боловсруулахад баримталсан зарчмын хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.

2.15. Харилцаа холбооны зохицуулах хороо нь олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хуульд нийцүүлэн батална.

2.16. Харилцаа холбооны зохицуулах хороо нь олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн саналын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн саналыг батлахдаа энэ журмын 2.12-т заасан зарчмыг хангасан эсэхийг хянан сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө баталж, олон нийтийн радио, телевизэд хүргүүлнэ.

2.17. Олон нийтийн радио, телевиз нь энэ журмын 2.16-д заасан сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийг өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

Гурав. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх

3.1. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-т заасныг баримтлахаас гадна хөтөлбөрт тусгасан бусад зар сурталчилгаа, нэвтрүүлгээс тодорхой ялган илэрхийлж, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг телевизийн тухайд нийт нэвтрүүлгийн туршид, радиогийн хувьд нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд заавал дурдана.

3.2. Радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12-т заасны дагуу сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах үүргийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

3.2.1. сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх хуваарь, цаг, үнэ тарифын саналыг батлан нам, эвсэл, нэр дэвшигчдэд хүргүүлж, ил тод мэдээлж ажиллана.

3.2.2. энэ журмын 3.2.1-д заасан саналыг баримтлан гэрээ байгуулахдаа ижил нөхцөл, боломж олгох;

3.2.3. энэ журмын 2.6-д заасан цагийн хуваарийг төлөвлөхдөө нэр дэвшигчийг дагнан нэвтрүүлэхгүй байхаар төлөвлөх.

3.3. Радио, телевиз нь мэдээ, мэдээллийн хөтөлбөрөөрөө зөвхөн нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн үйл явцын мэдээ, мэдээлэл гаргахыг дагнан гаргах гэж ойлгоно.

3.4. Радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.13-т заасан сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ хугацааны хувьд мөн тэнцвэртэй байх зарчмыг баримтална.

3.5. Радио, телевиз нь энэ журмын 3.1, 3.2-т заасан зарчмыг баримтлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх бөгөөд Монгол Улсын

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, энэ журамд зааснаас өөр арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байна.

3.6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6, 41.7, 41.14-т заасан сонгуулийн сурталчилгааны болон мэдээний хоногт гарах нийт хугацаанд тухайн нэвтрүүлгийн давталт хамаарна.

3.7.Радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.16-д заасан сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээг мэдээллийн хөтөлбөрөөс тусад нь энэ журмын 3.1-т заасныг баримтлан нэвтрүүлнэ.

3.8.Энэ журмын 3.1-т заасныг хангаагүй, сонгуулийн сурталчилгаа гэдгээ тодорхой илэрхийлээгүй, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй сонгуулийн сурталчилгааны болон сонгуулийн сурталчилгааны бус дараах нэвтрүүлэг гаргасан бол сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамааруулж тооцно. Үүнд:

3.8.1.нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлсэн бол;

3.8.2.захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой дурдаагүй аливаа нэвтрүүлэгт улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс, нэрийг үзэгч, сонгогчдод сонгуулийн сурталчилгаа гэж ойлгогдохуйц байдлаар харуулах, дурдах, байршуулах, дууны үгэнд дурдсан бол;

3.8.3.сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс бичлэг, яриа нь орсон бол.

3.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.14-т заасан мэдээний хоногт гарах таван минутын хугацааг мэдээний нэвтрүүлэгч тухайн мэдээг танилцуулж эхэлсэн хугацаанаас эхлэн тооцно.

3.10.Мэдээллийн хөтөлбөр дундуур дамжуулж буй сонгуулийн сурталчилгааны бус цаг үе үйл явдлын шинжтэй сурвалжлага, мэдээгээр нэр дэвшигчийн эрхэлж байгаа ажил үүрэгтэй холбоотой мэдээ, сурвалжлага гарах, мэдээ, сурвалжлага дундуур тухайн нэр дэвшигч тусгайлан яриа өгсөн бол сэдвээс үл хамаарч зөвхөн нэр дэвшигчийн яриа өгсөн цагийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.14-т заасан тухайн нэр дэвшигчид оногдох мэдээний 5 минутад хамааруулж тооцно.

3.11.Радио, телевизийн нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хугацааг Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журамд заасан зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй.

3.12.Радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.13-т заасныг хэрэгжүүлж, сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ мэдээллийг олон талын эх сурвалжаар баталгаажуулж, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчийн ёс зүйн зарчмыг мөрдөж ажиллана.

3.13.Хүүхэд, теле-худалдааны төрөлжсөн болон төлбөртэй радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байна.

3.14. Сонгуулийн талаарх дараах нэвтрүүлэг, сурталчилгаа нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй болно. Үүнд:

3.14.1. нам, эвсэл, нэр дэвшигчид болон сонгуулийн үйл явцын тухай радио, телевизийн өөрийн редакцийн бэлтгэсэн мэдээ, сурвалжлага, тойм;

3.14.2. сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа;

3.14.3. улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг;

3.14.4. сонгуулийн хороодын албан ёсны мэдээ.

3.15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.17-д заасны дагуу улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр нэвтрүүлэхдээ нийт нэр дэвшигчийг бүрэн оролцуулах, оролцогчдод ижил асуулт тавих, хариултын хугацаа тогтоох зэрэг мэтгэлцээний тогтсон дэгтэй байх ба оролцсон нэр дэвшигчдийн нэрийг намын харьяаллын хамт тодорхой илэрхийлсэн байна.

3.16. Телевиз нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2.4-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл болон улс төрийн мэтгэлцээн бэлтгэн хүргэхдээ хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай гаргана.

3.17. Сонгуулийн сурталчилгааг хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн хэлээр нь нэвтрүүлэхэд төрийн албан ёсны хэл болох Монгол хэлний хадмал орчуулгатай нэвтрүүлэх.

3.18. Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааг зогсоохдоо өөрийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан сонгуулийн сурталчилгаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.8-д заасан сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөрийг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл хязгаарлах арга хэмжээ авсан байна.

3.19. Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн үйл явцын мэдээллээс бусад сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах эсхүл сонгууль оролцогч нам, эвслийн дарга оролцсон аливаа нэвтрүүлэг, түүнчлэн тэдгээрийн таних тэмдэг, нэр, зураг, дүрс бичлэгийг гаргасан нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авсан байна.

3.20. Радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.1-д заасан сурталчилгааны цагийн төлөвлөсөн хуваарьт өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шалтгааны талаарх холбогдох нотлох баримтыг бүрдүүлсэн байна.

3.21. Радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой баримт болон сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн талаарх хуваарь, үнийн санал, гэрээ, эфирийн бичлэгийг нотлох баримт болгож 6 сараас доошгүй хугацаагаар хадгална.

3.22. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа радио, телевиз нь хэрэв Харилцаа холбооны зохицуулах хорооноос сонгуулийн сурталчилгааны хугацаанд эфирийн бичлэг хийх талаар урьдчилан мэдэгдэж, хуваарийн хамт хүргүүлсэн тохиолдолд заасан хугацаанд эфирийн нийт цагийн бичлэгийг тогтмол, тасалдалгүй бичиж, хуваарийн дагуу ирүүлнэ.

Дөрөв. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүрэг

4.1.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн сурталчилгааны хугацаанд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

4.1.1.сонгууль товлон зарласнаас хойш үйлчилгээнийхээ байнгын тасралтгүй ажиллагааг бүрэн хангаж, радио, телевизийн сувгийн дуу, дүрсийн чанарыг санаатайгаар бууруулахгүй байх, радио, телевизийн дохио, сигналыг таслахгүй байх, сувгийн дарааллыг өөрчлөхгүй байх зарчмыг хангаж ажиллах;

4.1.2.үйлчилгээний талаарх мэдээлэл, заавар зөвлөмж өгөх зориулалттай промо суваг, нүүр хуудас (постер)-аар сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх;

4.1.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т заасны дагуу өөрийн сүлжээгээр дамжиж байгаа сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизүүдийн ухраах, нөхөж үзэх үйлчилгээг санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас эхлэн санал авах хугацаа дуусах хүртэл зогсоох, энэ талаар хэрэглэгчид урьдчилан мэдээлэх;

4.1.4.интернэтэд суурилсан олон суваг дамжуулах үйлчилгээ (ОТТ)-д энэ журмын 4.1.3 мөн адил хамаарна.

4.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 43.15-д заасны дагуу Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт, радио, телевизийн хөтөлбөр дамжуулалтыг хязгаарлаж зогсоох тухай Харилцаа холбооны зохицуулах хорооны албан бичгийг үндэслэн тухайн радио, телевизийн хөтөлбөрийг зогсоох арга хэмжээг 3 хоногийн дотор арга хэмжээ авна.

4.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34.6, 43.11 болон энэ журмын 5.6-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас ирүүлсэн дүгнэлт, санал, радио, телевизийн хөтөлбөр дамжуулалтыг зогсоох тухай Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдлийг үндэслэн тухайн радио, телевизийн хөтөлбөрийг хязгаарлаж зогсоох арга хэмжээг даруй авна.

Тав. Сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих

5.1.Радио, телевизээр нэвтрүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргана.

5.2.Сонгуульд оролцогч нам, эсвэл, нэр дэвшигч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдолдхамаарах радио, телевизийн болон хөтөлбөр, нэвтрүүлгийн нэр, огноо, эхэлж дууссан цаг, минутын талаарх мэдээллийг заавал дурдана.

5.3.Энэ журмын 5.1-д заасан байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо өргөдөл, гомдолтой холбоотой нэвтрүүлгийн бичлэг, холбогдох бүртгэл, мэдээллийг шуурхай гаргаж өгнө.

5.4. Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийх явцад хууль, журам зөрчсөн байж болзошгүй тохиолдол бүртгэгдсэн, эсхүл радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхтэй холбоотой өргөдөл, гомдол хүлээн авсан тохиолдолд гомдлыг хянан үзээд өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад тайлбар, нотлох баримт, мэдээллийн хамт шилжүүлнэ.

5.5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34.1, 43.7, 43.8-д заасныг зөрчсөн нь тус хорооны хяналт, мониторингийн дүнгээр илэрсэн, энэ талаар гомдол ирсэн тохиолдолд харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад тайлбар, нотлох баримт, мэдээллийн хамт шилжүүлнэ.

5.6.Энэ журмын 5.5-д заасныг зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдож, зөрчлийн талаарх дүгнэлт, саналыг ирүүлсэн тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34.6, 43.11-т заасны дагуу тухайн радио, телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг хязгаарлах арга хэмжээг авна.

5.7.Харилцаа холбооны зохицуулах хороо нь хяналт тавихад ашиглаж байгаа мэдээ, мэдээллийг энэ журамд зааснаас өөр зорилгоор ашиглахгүй.

5.8.Олон нийтийн радио, телевиз болон бусад радио, телевиз нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д заасны дагуу сурталчилгаа нэвтрүүлсэн талаарх тайланг өөрийн цахим хуудсаар эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлж, нотлох баримтын хамт шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр 10 хоногийн дотор хүргүүлнэ.

5.9.Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт тавьж ажилласан талаарх тайланг олон нийтэд 15 хоногийн дотор мэдээлж ажиллана.

5.10.Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллахтай холбоотой эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах албан тушаалтны нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, факсын дугаар, цахим шуудангийн хаягийн талаарх мэдээллийг сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 15-с доошгүй хоногийн өмнө солилцоно.

5.11.Эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, энэхүү журмын хэрэгжилттэй холбоотой хяналтын дүн мэдээ, ирүүлсэн өргөдөл, гомдол болон хууль, журамд заасан зөрчлийн талаарх дүгнэлт, шийдвэрийг цахим шуудан, факсаар нэн даруй холбогдох газарт хүргүүлэх бөгөөд албан бичгийг шуудангаар хүргүүлнэ.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 3 дугаар сарын 14 ны өдрийн
32 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий
радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт**

1. Улаанбаатар хот: Радио, телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид

№	Телевиз, сувгийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Үйлчилгээний төрөл	Эзэмшлийн мэдээлэл		Хамрах хүрээ	Хаяг байршил, холбоо барих утас
				үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн нэр	эзэмшлийн хувь		
1							
2							
...							

**2. Аймаг, сум болон алслагдсан дүүрэг: Радио, телевизийн тусгай зөвшөөрөл
эзэмшигчид**

№	Телевиз, сувгийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Үйлчилгээний төрөл	Эзэмшлийн мэдээлэл		Хамрах хүрээ	Хаяг байршил, холбоо барих утас
				үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн нэр	эзэмшлийн хувь		
1							
2							
...							

---oOo---